

АЗИН ОРНУУД
БА ШИНЭТГЭЛАЗИЙН ОРНУУДАД ӨМЧ ХУВЬЧИЛСНЫ
ТУРШЛАГА, СУРГАМЖ***В. Михеев**

80-аад онд азийн шинээр аж үйлдвэржсэн орнуудад (Өмнөд Солонгос, Сингапур, Гонконг, Тайвань болон эдгээр орны хөгжлийн төвшинд ойртож буй Малайз, Тайланд, Индонези, Филиппиныг оруулж байна. -Орч.) төрийн оролцоог аж ахуйн үйл ажиллагаанд багасгах замаар түүний гол субъект-үйлдвэрийн үүргийг дээшлүүлэх болсон нь эдийн засгийн бодлогын шинэ үе эхэлсэн билээ. Амины, хувийн, хоршоолол, хувь нийлүүлсэн нийгэмлэг нэрийн дор гарч ирж буй хувийн санаачлагыг «хөгжлийн гол хурдасгуур» хэмээн үзэж байна. Төрийн зохицуулалт гол төлөв стратегийн зорилт, тухайлбал аж ахуйн үйл ажиллагаанд дэг журам тогтоох, чөлөөт үйлдвэрлэгчдийн хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэлтийг хөхүүлэн дэмжих тийш чиглэж, тушаал лүндэн буулгах, ивээн тэтгэх явдал эдийн засгийн дам зохицуулалтанд байраа тавьж байна.

Азийн орнууд нийгмийн дэвшил дэх төрийн ба төрийн бус зохицуулагчийн харьцааг хянан үзэх болсон нь хөгжлийн дотоод, гадаад хүчин зүйл өөрчлөгдсөний тусгал юм. Улсын секторт асуудал бэрхшээл хуримтлагдан дээд цэгтээ тулж, дэлхийн эдийн засагт томоохон өөрчлөлт гарч, дээрх орнуудын улсын төсвийн алдагдал асар их хэмжээнд хүрчээ.

80-аад оны эхээр төрөөс эдийн засагт хутгалдан орсны уршиг дагаврын талаар хөгжиж буй 20 гаруй оронд НҮБ-ын ивээл доор хийсэн судалгаагаар төрөөс эдийн засагт хэдийчинээ шууд хутгалдан оролцох тутам хөгжилд төдийчинээ бэрхшээл тулгарч байна гэсэн магадлагаа гаргажээ. Гэхдээ тодорхой хэмжээнд хүртэл төрийн зохицуулалт аж ахуйн хөгжилд тус дөхөм үзүүлдэг. Судлаачид улсын үйлдвэрийн ажил тааруу явагддаг гол шалтгааныг үйлдвэрлэлийн зардлыг бууруулахад урамшуулал байхгүй; ашиг, чанарын төлөө чармайдаггүй; ажилчдын цалин үйлдвэрлэлийн үр ашигтай шууд холбогдож чаддаггүй гэсэн 3 дутагдлаар тайлбарласан байна.

Гадаад хүчин зүйлийн хувьд «эдийн засгийн шинэ бодлого»-ыг Өрнөдийн хөгжингүй орнууд гаалиар хавчих явдлаа хүчтэй болгосны зэрэгцээ өр зээлийн асуудалд хурцдан, гадаад хөрөнгө оруулалт багасах хандлага ажиглагдаж эхэлжээ. Дээрх орнууд төсвийн зардлаа багасгах буюу хэвээр хадгалах, улсын бус салбараас эдийн засагт орж ирэх санхүүгийн нөөцийг нэмэгдүүлэх чиглэл баримтлах болов.

Өмч хувьчлах (приватизация) гэдгийг эхний үед хувийн секторын ажлын үр ашгийг сайжруулах буюу түүнийг хөгжүүлэх бодлого төдийгөөр ойлгож байв. Хөгжингүй капиталист орнуудад өргөн тархсан улсын үйлдвэрийг хувьд худалдана гэсэн явцуу ойлголт ч байлаа.

Харин азийн орнуудад өмч хувьчлал нь улсын өмчийг устгах бус, шууд үйлдвэрлэгчдийн аж ахуйн болон технологийн санаачлагыг чөлөөтэй тавьж өгөх байдлаар өрнөсөн юм. Хувьчлах чиг бодлого бол улсын үйлдвэрийн үйл ажиллагаан дахь хүнд суртлын хяналт шалгалтыг

***В. В. Михеев.** «В поисках альтернативы, Азиатские модели. Развития: Социалистические и новые Индустриальные страны» Москва, 1990, с. 102-116 номноос товчлон орчуулав.

арилган, тэдэнд «удирдлага, санхүүгийн бие даах эрх, шуурхай ажиллах бололцоо олгох замаар эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилготой юм. Улсын монополийг хадгалах үүднээс аль нэг салбарыг чөлөөт үйлдвэрлэгчдийн өрсөлдөөнөөс хамгаалсан элдэв хаалт хязгаарлалтыг арилгахад чиглэсэн арга хэмжээнүүд ч уг чиг бодлогын бүрэлдэхүүн хэсэг болно.

Өмч хувьчлал орон бүрд харилцан адилгүй явагддаг боловч дараахь үндсэн зорилтыг баримталж байна. Үүнд: засгийн газраас үүрэх санхүүгийн ачааллыг багасгах улсын секторын үр ашгийг дээшлүүлэх, улсын бус хөрөнгө оруулалтыг ашиглах замаар хөгжлийг түргэтгэх; улсын монопол, хүнд суртлыг арилгах, капитал, үнэт цаас, валютын зах зээл бий болгох; гадаад өр зээлд хүлээх хариуцлагыг засгийн газар, чөлөөт үйлдвэрлэгчид хуваах; чөлөөт үйлдвэрлэгчдийг дэд бүтэц, боловсрол зэрэг засгийн газрын уламжлалт салбарт татан оролцуулах эд бүгд болно.

Хэрэв өмчийн нэг хэлбэрийг нөгөөгөөр солибол монополийг устгаж, зах зээлийг хөгжүүлэхгүй, эдийн засагт ямар ч үр өгөөж өгөхгүй. Юуны түрүүнд эдийн засгийн «шинэ» салбаруудад өрсөлдөөн хөгжөөхийг эрмэлзвэл зохино.

Өмч хувьчлалыг дараахь чиглэлүүдээр хэрэгжүүлж байна. Үүнд:

1-рт, Засгийн газраас үйлдвэр байгуулж өмчлөх эрхээ хэвээр хадгалан гагцхүү түүнийг эрхлэн хөтлөх эрхийг хувь хүмүүст шилжүүлнэ. Хувийн өмчийн амжилт баталгаажуагүй, аз сорихоос болгоомжилж буй үед энэ нь илүү зохимжтой.

2-рт, улсын үйлдвэрийг хувь нийлүүлэгчдэд худалдаж хамтран эрхлэх, аажмаар чөлөөт үйлдвэрлэгчдэд бүрэн шилжүүлнэ. Ийм хувилбарыг үнэт цаасны зах зээл их хөгжсөн нөхцөлд, эсвэл стратегийн чухал ач холбогдол бүхий чухал салбаруудад хяналтаа хэвээр үлдээж үр ашгийг дээшлүүлэхийг эрмэлзэж буй нөхцөлд хэрэглэж байна.

3-рт, Үйлдвэрийг нэг болон хэсэг хуулийн этгээдэд үнэ хаялцуулан худалдах;

4-рт, Улсын үйлдвэрийг устган, түүний оронд хувийн сектор ажиллах нөхцөл бүрдүүлэх;

5-рт; «Дам аргаар» өмч хувьчлах буюу улсын бус үйлдвэрүүдэд зээл татварын талаар янз бүрийн хөнгөлөлт үзүүлж, уг салбар дахь улсын монополийг сулруулж, үнийг бууруулахыг зорьдог. Эсвэл улсын үйлдвэрийн газар дахь үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүнийг хуваарилах, борлуулах эрхийг хувийн секторт шилжүүлж байна.

Дээр дурьдсан орнуудад явагдаж буй өмч хувьчлах ажил ихээхэн бэрхшээлтэй байгаагийн дотор нийгэмд эзэлсэн байр суурийг нь заналхийлж буй хүнд суртал хамгийн их эсэргүүцэл үзүүлж байна. Энэ үйл явцыг удирдлагын хүрээнд зөвхөн үндэсний хөгжлийн асуудлыг өргөн хүрээнд үзэх чадвар бүхий төрийн дэвшилт үзэлтэй зүтгэлтнүүд, амины болон хувийн үйлдвэрлэл хийхийг зөвшөөрснөөр «гараа цайлгах» боломж олдох янз бүрийн шатны түшмэд дэмжиж байгаа юм.

Өөр нэг асуудал бол өмч хувьчлах цаг хугацаа, арга замыг сонгох, асуудал юм. Хэргийн учир салбар бүрт өмчийн хэлбэрийг хослуулах хамгийн зохистой харьцааг тогтооход оршино. Зарим салбарт улсын сектор, нөгөөд нь хоёр сектор түншийн ёсоор хамтран ажиллаж, 3 дахь салбарт улсын секторын үр ашиг муу байх жишээтэй. Сонголт зөв болсон эсэхийг гагцхүү цаг хугацаа өнгөрсний хойно, зах зээлээр дамжин илэрнэ. Түүхий эд олборлох, эрчим хүч, зам тээврийн сал-

барт өмч хувьчлах ажил хамгийн их бэрхшээлтэй тулгардаг. Нэг талаас хөрөнгө мөнгө их шаардаж, зардлаа нөхөхдөө удаан эдгээр салбарт хувийн сектор дуртай бус, нөгөө талаас төрөөс стратегийн суурь салбар дахь байр сууриа тавьж өгөх, тэр байтугай хяналтаа сулруулахыг ямагт зөвшөөрдөггүй. Үр ашгаа тодорхой харуулж чаддаг үйлчилгээ, хэрэглээний барааны үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт өмч хувьчлах үйл явц арай хялбар өрнөдөг. Нийгмийн шинжтэй саад бэрхшээлүүд ч байна. Үүнд ажлын байр багасч, ажилгүйдэл ихсэх, өмчийн хэлбэр солигдсоноос хөдөлмөрчдөд нийгмийн хөнгөлөлтөөс ангижрах аюул өсөх, мэргэшлийн зэрэглэлээ алдах, шинэ эзэд хуучин хэмжүүрийг хэрэгсэхгүй болж, сургалт шинээр явуулахыг шаардах зэрэг болно.

Үйлдвэр хувьд шилжиж, гадаадын шинэ технологи эзэмшилтэй уялдан нийгэм-сэтгэл зүйн таагүй уршиг дагавар ч гарч ирдэг. Азийн орнуудад нийгмийн эдгээр сөрөг үр дагаврыг багасгах арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Үүнтэй уялдан өмч хувьчлахдаа үйлдвэрийг ажилчдад нь шилжүүлж хоршоолол буюу хувь нийлүүлсэн нийгэмлэг болгох; ажилчид, шинэ эздийн амин сонирхлыг нийцүүлэх зорилгоор түр арбитрын газруудыг байгуулах; өмч хувьчилсны дүнд ажилгүй хоцорсон хүмүүсийг дахин сургах засгийн газрын программ боловсруулж, нэвтрүүлэх зэрэг санал дэвшүүлж байна.

Өмч хувьчлах үйл явц (Гонконг, Сингапур, зарим үед Өмнөд Солонгос) хөрөнгийн зах зээл хөгжөөгүйгээс, хүн амын мөнгөн хадгаламж капитал болоход түвэг бэрхшээлтэй учирдаг тул удааширч байна. Нэгэнт зах зээл хөгжөөгүй эксперт, санхүү, банкны мэргэжилтэн дутагдалтай учир худалдах үйлдвэрт үнэлгээ өгөх бүх ажил, хариуцлага нь засаг захиргааны байгууллагуудад оногддог. Үүнд Ази дахь өмч хувьчлах ажлын зөрчил байгаа юм. Тэгээд ч засаг захиргааны аппарат «үүргээ» өөрчлөх хэрэгтэй болдог.

Өөр нэг асуудал бол санхүү-зээлийн систем хөгжөөгүй, хөрөнгө мөнгөөр хясагдах явдал юм. Зээлийн сул систем нь улсын өмчийг худалдан авахдаа санхүүгийн зах зээлийг хоосруулахад хүргэнэ. Энэ асуудлуудыг үндэсний зээлийн системийг хөгжүүлэн гадаадын түншүүдийг татаж оруулах замаар шийдвэрлэж болох юм.

Гонконг улсын хяналт зөвхөн усан хангамж (ус эх газраас ус авдагтай уялдан) болон шуудан холбоонд байдаг. Мөн түүнчлэн худалдаа хөгжлийн зөвлөл, Экспорт-зээлийн даатгалын компани, Транзит тээврийн байгууллага зэрэг хагас улсын аж ахуйн газрууд байдаг. 80-аад оноос эдгээр байгууллагын үр ашиг, ажлын шуурхай байдлыг дээшлүүлэх зорилгоор тэнд тавих улсын хяналтыг хязгаарлах чиг шугам баримтлах болов.

Сингапур. Үндэсний нийт бүтээгдэхүүний 25 % орчмыг үйлдвэрлэдэг 450 компанийг хянаж байдгийн хувьд үндэсний эдийн засагт төр ихээхэн үүрэг гүйцэтгэдэг.

Өмч хувьчлахын гол зорилго засгийн газрын зүгээс «шударга бус өрсөлдөөн», чадварлаг удирдах боловсон хүчнийг улс татан авахыг» арилгах замаар хувийн сектортой өрсөлдөхийг багасгахад чиглэж байна.

1984 онд эдийн засагт төрийн гүйцэтгэх үүргийг ул суурьтай хянан үзэж, ямар нэг үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөөц бололцоогүй болох буюу түүнийг хөгжүүлснээр үр ашиггүй байх тохиолдолд төрийн зүгээс зах зээлийн үйл ажиллагаанд оролцохоор шийдвэрлэжээ.

Нийт үндэсний эрх ашгийг хөндсөн ажил, үйлчилгээ эрхэлдэг компанийн үйл ажиллагаанд төрийн зүгээс хяналтаа хэвээр байлгана. Төрөөс оролцох шаардлагагүй холимог компаний хувьцааг хувьд худалдахаар тогтжээ.

1984 онд улсын хөрөнгө оруулалтын томоохон компани «Темасек хувьцааныхаа 45 % худалдсанаар өмч хувьчлах анхны том алхам хийсэн юм. Мөн онд засгийн газар «Мицу биси Сингапур хеви индастриз» хэмээх япон, сингапурын компаний хувьцааг үнэт цаасны зах дээр борлуулав. 1986 онд энэ ажил шинэ үе шатанд орж «Улсын өмч хуваах» засгийн газрын хороог байгуулжээ.

Өмнөд Солонгос. Улсын үйлдвэрүүд үндэсний эдийн засгийг хөгжүүлэхэд маш их үүрэг гүйцэтгэсэн бөгөөд ялангуяа 60—70-аад онд эрчимтэй хөгжсөн. Энэ үед хөрөнгө оруулалтын 90 хувийг улсын банкаар хийж байв. Улсын үйлдвэрүүдэд бүтээгдэхүүний гуравны нэг, тээврийн үйлчилгээний 20 хувь оногдож байлаа. Одоо улсын 100 үйлдвэр байгаагаас 26 нь засгийн газрын шууд хяналтанд, 74 нь холимог буюу улсын татаасаар ажилладаг байна. Юуны өмнө ган, химийн бордоо зэрэг стратегийн чухал ач холбогдол бүхий салбаруудад хяналт тавьдаг.

Өмч хувьчлах ажлын гол чиглэл өмчийн хэлбэрийг солиход бус улсын үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэж байна. Өмнөд Солонгосын энэ онцлог байдал үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагааг хэдэн гэр бүл толгойлдог санхүү аж үйлдвэрийн бүлгийнхэн явуулдагт оршино. 10 том бүлэгт үндэсний нийт бүтээгдэхүүний 60 хувь, экспортын 70 хувь оногддог.

1983 он хүртэл үе үе улсын үйлдвэрийг худалдах явдал гардаг байв. 1969 онд агаарын тээврийн КАЛ компанийг, 1982 онд «Кореан оил», «Кореан хеви индастриз» 2 компанийг хувьд шилжүүлсэн. Харин 1983 оноос санхүүгийн салбарт хувьд шилжүүлэх ажлыг түргэвчлэх бодлого явуулж эхэлсэн. Арилжааны 7 банкиг хувь хүмүүст өгч, арилжааны холимог банк 2-ыг шинээр байгуулснаас гадна хадгаламжийн болон санхүүгийн 43 компани, богино хугацааны зээл дагнан эрхэлдэг 10 компанийг мөн хувьд шилжүүлэв.

Улсын үйлдвэр аж ахуйн газрыг данслан бүртгэж, өмч хувьчлах ажлыг зүй зохистой явуулахад зөвлөмж болгох үүднээс улсын үйлдвэрийг удирдах тухай тусгай хуулийг 1983 онд гаргаж, 1984 онд улсын корпорацийн ажлыг үнэлэх товчоог байгуулжээ.

1988 онд Сеулын зүгээс «эдийн засгаа өөрчлөн шинэчлэх хөтөлбөр боловсруулан батлав. Хөтөлбөрийн гол зорилго банк болон санхүүгийн бусад байгууллагуудад илүү эрх мэдэл олгож, үндэсний зах зээл дэх гадаадын пүүсний үйл ажиллагаанд тавьсан хатуу хязгаарлалтыг цуцлах замаар эдийн засгийг либералчлан, улам бүр нээлттэй болгох явдал юм.

Малайз. АСЕАН-ын бусад орнуудтай харьцуулбал хөгжлийн нийгмийн асуудалд илүү их анхаардаг. Тийм ч учраас эдийн засагт эзлэх улсын секторын хувийн жин бусад орнуудаас их юм. Засгийн газар улсын янз бүрийн байгууллагуудаар дамжуулан банк, үйлдвэр, нийгмийн дэд бүтэц, дал модны тариалангийн газар, телевиз, усан буудлыг хяналтандаа байлгадаг. Малайзын экспорт түүхий эдийн шинжтэй, тэгээд ч нефть, хар тугалга, дал модны тосны дэлхийн зах зээлийн онцлог зэрэг нь улсын сектор зонхилох нөхцөл бүрдүүлж байна.

80-аад онд түүхий эдийн үнэ буурч гадаадаас орж ирэх хөрөнгө мөнгө багассан нь төсвийн хүнд байдал үүсгэж, засгийн газар зард-

лаа багасгахад хүрсэн юм. Гэвч нийгмийн асуудлыг тулхүү анхаарч буй «эдийн засгийн шинэ бодлого» нь төрийн оролцоог илүү их шаарддаг тул өмч хувьчлах ажилтай нэлээд зөрчилдөх болсон юм.

1985 онд английн эдийн засагчид, санхүүгийн шинжээч нарыг идэвхтэй оролцуулан өмч хувьчлах хөтөлбөрийг боловсруулан батлав. Санхүүгийн бус 900 гаруй корпорацийг хувьчлах чиглэл барьж буй боловч «эдийн засгийн шинэ бодлого»-ыг баримтлагсад өмчийн хэлбэрийг өөрчлөлгүй, харин улсын үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэхийг нэлээд чухалчилж байна.

1983 онд теленэвтрүүлгийн 1 сувгийг, 1985 онд сугалааг улсын агаарын тээврийн компани хувьцааны 30%, 1988 онд дахин 40%-ийг хувьд өгчээ. 1986 онд 3,4 тэрбум долларын өртөг бүхий автозамыг барих улсын болон хувийн пүүсүүд, хамтран томоохон төслийг дэмжсэн бөгөөд 25 жилийн дараа өмчийг засгийн газарт шилжүүлэх ажээ.

Өмч хувьчлах ажил эдийн засгийг хөгжүүлэх өнөөгийн хөтөлбөрийг дуусгаж, 90-ээд онд аж ахуйн үйл ажиллагааг либералчлахыг онцлон буй шинэ бодлогод шилжсэнтэй уялдан хурдасч ирэх юм. Ингэснээр засгийн газраас үзүүлдэг нөлөөг сулруулж, хөрөнгө их шаарддаг ган хайлуулалт, хими, машины үйлдвэрт улсын бус салбарын хөрөнгө оруулалтыг татан оруулахыг хөхүүлэн дэмжих ажээ.

Филиппин. Энэ улсын удирдлага «худалдаа, наймааны ажилд төрөөс аль болох хутгалдахгүй байх ёстой» гэсэн үзэл санаа баримталдаг, мөн түүнчлэн Маркосын захиргааны үед хүнд байдалд орсон эдийн засгаа өөд татах шаардлага, улсын үйлдвэрийн үрэлгэн, үр ашиггүй ажил зэрэг нь өмч хувьчлах үндэс суурь, гол хүчин зүйл болж байна.

80-аад оны дундуур Филиппинд сангийн сайд удирдсан өмч хувьчлах хороог байгуулжээ. Одоо улсын 100 үйлдвэрийг хувьд шилжүүлэх ажил өрнөж байна. Гол хүчин чармайлтаа худалдааг чөлөөтэй болгох, өөрөөр хэлбэл гаалийн бус элдэв хаалт саадыг арилгаж, гаалийн (импортын), татварыг доошлуулж байна. Гэхдээ энэ ажилд үйлдвэрчний зүгээс хүчтэй эсэргүүцэл үзүүлж, хувийн үйлдвэрлэлд үл итгэсэн байдал, байнга гарах ажил хаялт түүнд сөрөг нөлөөлсөөр байна. Тус оронд улс төрийн байдал тогтворжиж, өр зээлийн төлөх хугацааг сунгасан нь 90-ээд онд эдийн засгийн шинэ үзэл баримтлалыг хэрэгжүүлэх таатай нөхцөл бүрдүүлэх юм.

Сүүлийн жилүүдэд **Тайланд** эдийн засгийн талаар олсон амжилтын гол үндэс суурь гадаадаас хөрөнгө ихээр орж ирсэн, фермерийн үүргийг өндөржүүлэх чиглэл бүхий хөдөө аж ахуйн үр ашигтай бодлого хэрэгжүүлж, засгийн газраас нийгмийн дэд бүтцийг хөгжүүлж, хөдөө тосгоны материаллаг хангалтыг хөхүүлэн дэмжсэнд оршино. Ерөнхий сайдын удирдлагаар улсын ба хувийн аж ахуйн тусгай хороог 80 аад оны эхээр байгуулснаар эдийн засгийн санаачлагын 2 эх үүсвэрийн харилцааг зохицуулах эхлэл тавигдсан. Тэгээд ч уг хороо өмч хувьчлах ажилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна.

Тус улсад одоо улсын 70 үйлдвэр байгаагаас ихэнх нь үр ашиг муутай бөгөөд тэдний үйлдвэрлэлийн зардлыг нөхөхөд үндэсний нийт бүтээгдэхүүний 3,5 хувийг зарцуулдаг. 1984 онд хэсэгчлэн хувьчлах хөтөлбөрийн гол зорилго энэ ачааг сулруулахад чиглэжээ. Энэхүү хөтөлбөр ёсоор эрчим хүч, авто тээвэр, жуулчлал, уламжлалт гар урлалын салбар дахь улсын компанийн үнэт цаас, хувьцааг үндэсний зах зээл дээр борлуулах ажээ. Зам барих, телефон харилцааны систем байгуулах зэрэг дэд бүтцийг хөгжүүлэх төсөлд хувийн сектор идэвхтэй оролцож байна.

Гол асуудал бэрхшээл үйлдвэр-худалдааныханд алдагдалтай үйлдвэрүүдийг худалдан авах боломж муугаас гадна аж ахуйн амь өрссөн зоримог алхам хийх тул түүнийг авахыг нэг их хүсэхгүй байгаатай холбоотой юм. Мөн түүнчлэн өмч хувьчлах ажил хүнд суртлын сунжирсан үе шатыг дамжиж байгаа, өндөр мэрэгшлийн мэргэжилтнүүд дутагдалтай, тэднийг бэлтгэн авах бэл бэнчин байхгүйтэй ч холбоотой.

Дээр дурьдсан орнууд дахь өмч хувьчлал зарим зүйл азийн социалист орнуудад эдийн засгийн шинэ загварт шилжих асуудлуудтай нэлээд ижил төстэй байна. Мөн чанартаа аль алинд нь үндэсний эдийн засгийг нийгмийн нийт хэрэгцээг хангах ажлын дээд байгууллагын тушаалаар гүйцэтгэдэг тийм байдлаас гаргаж, эрэлт хэрэгцээ, ашиг орлогоо үйлдвэрлэгч өөрөө зохицуулах механизмд шилжих асуудал хөндөгдөж байна. Гаргасан шийдвэрийн зөв эсэх зах зээлээр шалгагдаж байгаа юм.

Өмч хувьчлахын гол утга учир бүрэлдэн буй зах зээлийн нөхцөлд улсын монопол, өрсөлдөөний хамгийн ашигтай харьцаа тогтооход оршино. Зах зээл хөгжсөн нөхцөлд таваарын үнэ, түүний шаардлагатай тоо хэмжээ эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээс хамаардаг нь бүхэнд илэрхий. Гэхдээ үнэ нь үйлдвэрлэгчийн ашгийг хангахын тулд үйлдвэрлэлийн зардлаас дээгүүр байх ёстой.

Эдийн засаг сул хөгжсөн орнуудад олонхи бараа нь үйлдвэрлэгчид ашиг олж ирэхүйц зах зээлийн тэнцвэртэй байдлыг бүрдүүлж чаддаггүй. Технологийн хоцрогдол нь техникийн шинэ санааг нэвтрүүлж үйлдвэрлэлийн зардлыг бууруулах боломж олгодоггүй. Үйлдвэрлэгч хангалттай хуримтлал бий болгож чаддаггүй нь бүтээгдэхүүний өөрийн өртгийг хямдруулахын тулд үйлдвэрлэлээ өргөтгөх хүчин зүйлийг ашиглахад бэрхтэй болгодог. Хэрэглэгч үйлдвэрлэгч ашиг орлоготой ажиллахад түлхэц өгөхүйц тийм үнэ төлөхөд бэлэн бус байдаг. Энэ бүхний дунд амин чухал бүтээгдэхүүн ч үйлдвэрлэгчид ашиггүй байх нь олонтаа гардаг.

Энэ тохиолдолд нийгмийн хэрэгцээг хангах үүднээс зохистой доогуур үнийг тогтоож, үйлдвэрлэлийн зардлыг улсын төсвөөс нөхнө. Энд ашигтай ажиллах сонирхол зайлшгүй эрэлт хэрэгцээг хангах зорилгод хүчээр захирагдаж байна. Гэвч аажмаар эрэлт хэрэгцээг өсгөн үйлдвэрлэл өргөжих буюу шинэ техник нэвтрүүлснээр үйлдвэрлэл зардал буурч үнэ өртөг зардлаа нөхөж, үйлдвэрлэгчид орлоготой болох нөхцөл бүрэлдэнэ. Энэ үеэс улсын ивээл, бөөцийлөл эдийн засагт хор ур шиг учруулдаг. Амьдрал дээр төрийн зохицуулалтыг ашиг орлого гэсэн урамшууллаар солих ёстой «эгзэгтэй үе»-ийг тогтооход маш хэцүү. Цаг тухайд нь «хямралт байдлаа» зөв тогтоож, өмч хувьчлах ажилд шилжих нь аль ч орны эдийн засгийн хөгжлийн үр ашгийг шийдвэрлэх хэмжээгээр тодорхойлох ажээ. Засаг төрөөс л өмч задлах ажлыг өрнүүлэн явуулах тул дам зохицуулалтыг сайжруулах шаардлага зүй ёсоор урган гардаг.